



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 12 сарын 05 өдөр

Дугаар СХШ-2025/24

Сүхбаатар сум

Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын
газрын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн
хяналт шалгалтын дүн

**Нэг: Хяналт шалгалтын зорилго, хамарсан хүрээ, хугацаа, шалгуулсан
байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалт**

1.1. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын баталсан 2025 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн СХШ-25/08-ТШЗ дугаартай "Санхүүгийн хяналтын ажлын удирдамж"-аар Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газрын санхүү төсвийн гүйцэтгэл болон Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиуд болон Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан эрх зүйн актуудын хэрэгжилтийг хянан шалгах, илэрсэн зөрчил дутагдалд үнэлэлт дүгнэлт өгөх, залруулах зорилготойгоор хяналт шалгалтыг гүйцэтгэлээ.

1.2. Шалгалтыг Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын СХШУАБ Т.Мөнхзул 2025 оны 08 дугаар сарын 12 -ны өдрөөс 2025 оны 09 дүгээр сарын 12 -ны өдрийг дуустал хийж гүйцэтгэлээ.

1.3. Шалгалтад Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газар (цаашид аймгийн ЗДТГ гэх)-ын 2024 он 2025 оны 2 дугаар улирлын санхүү, төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагааны баримт материал, тайлан тооцоог хамруулав.

1.4. Аймгийн ЗДТГ нь улсын бүртгэлийн 9055053 дугаар регистртэй, Төрийн сан дах үндсэн үйл ажиллагааны 100130051026 дугаартай данс, нэмэлт санхүүжилтийн 100130051415 дугаартай данснуудыг ашиглаж байна.

1.5. Аймгийн ЗДТГ нь Төсвийн орлого зарлага, тайлагналт, Төрийн сангийн харилцах дансанд 1-р гарын үсгийг сумын ЗДТГ-ын дарга Ө.Сувдаа, 2-р гарын үсгийг ахлах нягтлан бодогч Х.Сүнжидмаа, Ц.Уранцэцэг нар зурж төсвийн хөрөнгийг захиран зарцуулсан байна.

1.6. Аймгийн ЗДТГ нь 2025 онд улс төрийн албан тушаалтан 2, төрийн тусгай албан хаагч 4, төрийн захиргааны албан хаагч 51, төрийн үйлчилгээний бусад албан хаагч 45 нийт 102 хүний орон тоо баталж, удирдах ажилтан 9, гүйцэтгэх ажилтан 46, үйлчилэх ажилтан 40 нийт 95 орон тоогоор үйл ажиллагаа явуулж байна.

Хоёр. Шалгалтад хамрагдах асуудлууд

2.1 Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт

2.1.1 Аймгийн ЗДТГ нь санхүүгийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад санхүүгийн хууль тогтоомжийн хүрээнд УСНББОУС, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдлөг болгон нягтлан бодох бүртгэлийг хөтлөн явуулж байгаа боловч тэдгээртэй холбоотой хууль тогтоомж зөрчих үйлдэл оршсоор байна.

2.2. Батлагдсан төсөв, гүйцэтгэл зориулалтын дагуу зарцуулсан байдал

2.2.1 Батлагдсан төсөв:

Засаг даргын Тамгын газрын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 5,727,649.4 мянган төгрөг, өөрийн орлого 45,000.0 мянга төгрөг, нийт 5,772,649.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөснийг 1,627,798.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 7,400,448.3 мянган төгрөгөөр батласан байна. Тайлант оны дундуур батлагдсан төсвийг 201,358.5 мянган төгрөгөөр Засаг даргын нөөц хөрөнгийн төсвийг нэмэгдүүлэн төсвийн тодотгол хийж, 7,601,806.8 мянган төгрөгөөр эцэслэн баталсан баталжээ.

Гүйцэтгэл 2024 онд 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 7,601,806.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 6,372,594.5 мянган төгрөг, 2025 оны хагас жилээр 3,865,556.6 мянган төгрөгөөр санхүүжихээр төсөв батлагдсанаас 3,292,005.1 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 01. /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2024 он				2025 оны хагас жилээр			
	Төлөв лөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт /-/ Хэмнэлт /+/ %	Гүйц %	Төлөв лөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт /-/ Хэмнэлт /+/ %	Гүйц %
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,601,806.8	6,372,594.5	1,229,212.3	83.8	3,865,556.6	3,292,005.1	573,551.5	85.2
УРСГАЛ ЗАРДАЛ	7,601,806.8	6,372,594.5	1,229,212.3	83.8	3,865,556.6	3,292,005.1	573,551.5	85.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,137,745.5	5,993,867.0	1,143,878.5	84.0	3,740,578.1	3,205,994.0	534,584.1	85.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,907,875.5	3,123,178.4	784,697.1	79.9	1,973,364.0	1,881,941.1	91,422.9	95.4
Үндсэн цалин	1,544,333.7	1,654,436.8	-110,103.1	107.1	833,375.8	816,852.3	16,523.5	98.0
Нэмэгдэл	1,811,691.6	1,077,694.5	733,997.1	59.5	850,547.0	724,300.2	126,246.8	85.2
Унаа хоолны хөнгөлөлт	277,200.0	186,592.2	90,607.8	67.3	148,104.0	245,161.1	-97,057.1	165.5
Урамшуулал	274,650.2	204,454.9	70,195.3	74.4	141,337.2	95,627.4	45,709.8	67.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	508,459.5	380,298.8	128,160.7	74.8	246,670.8	210,699.0	35,971.8	85.4
Тэтгэврийн даатгал	345,752.4	259,670.9	86,081.5	75.1	167,736.0	144,427.6	23,308.4	86.1
Тэтгэмжийн даатгал	40,676.7	33,923.5	6,753.2	83.4	19,734.0	17,000.5	2,733.5	86.1
ҮОМШӨ-ний даатгал	9,913.1	16,505.0	-6,591.9	166.5	11,998.2	8,819.8	3,178.4	73.5
Ажилгүйдлийн даатгал	30,763.7	13,326.2	17,437.5	43.3	7,735.2	7,757.6	-22.4	100.3
Эрүүл мэндийн даатгал	81,353.6	56,873.2	24,480.4	69.9	39,467.4	32,693.5	6,773.9	82.8

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	655,408.6	595,363.5	60,045.1	90.8	416,940.8	349,640.0	67,300.8	83.9
Гэрэл, цахилгаан	44,716.4	29,632.4	15,084.0	66.3	23,014.8	23,251.8	-237.0	101.0
Түлш, халаалт	518,557.4	472,747.2	45,810.2	91.2	345,595.5	282,842.1	62,753.4	81.8
Цэвэр, бохир ус	35,559.5	39,204.8	-3,645.3	110.3	18,780.0	19,541.0	-761.0	104.1
Байрны түрээс	56,575.3	53,779.1	2,796.2	95.1	29,550.5	24,005.1	5,545.4	81.2
Хангамж, бараа материалын зардал	227,552.6	215,279.1	12,273.5	94.6	103,186.0	96,265.6	6,920.4	93.3
Бичиг хэрэг	48,897.2	35,911.5	12,985.8	73.4	10,045.2	9,049.4	995.8	90.1
Тээвэр, шатахуун	90,639.2	90,631.3	7.9	100.0	58,284.4	48,440.8	9,843.6	83.1
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	31,658.0	33,594.0	-1,936.0	106.1	14,246.4	15,624.6	-1,378.2	109.7
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	404.2	720.0	-315.8	178.1	360.0	360.0	0.0	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	55,954.0	54,422.3	1,531.7	97.3	20,250.0	22,790.8	-2,540.8	112.5
Нормативт зардал	5,000.0	4,999.7	0.4	100.0	3,290.0	0.0	3,290.0	0.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,000.0	4,999.7	0.4	100.0	3,290.0	0.0	3,290.0	0.0
Эд хогшил, урсгал засварын зардал	170,550.0	168,978.2	1,571.8	99.1	55,735.0	36,428.4	19,306.6	65.4
Багаж, техник, хэрэгсэл	62,500.0	61,478.9	1,021.1	98.4	15,099.6	9,178.6	5,921.0	60.8
Тавилга	20,950.0	20,794.9	155.1	99.3	0.0	0.0	0.0	
Урсгал засвар	87,100.0	86,704.4	395.6	99.5	40,635.4	27,249.8	13,385.6	67.1
Томилолт, зочны зардал	208,234.0	187,377.7	20,856.3	90.0	95,985.0	90,272.5	5,712.5	94.0
Дотоод албан томилолт	194,234.0	176,258.8	17,975.2	90.7	89,985.0	86,827.9	3,157.1	96.5
Зочин төлөөлөгч хүлээн авах	14,000.0	11,118.9	2,881.1	79.4	6,000.0	3,444.6	2,555.4	57.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	75,033.0	69,542.9	5,490.1	92.7	20,156.5	6,991.9	13,164.6	34.7
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	58,160.0	56,056.4	2,103.6	96.4	6,000.0	3,969.5	2,030.5	66.2
Даатгалын үйлчилгээ	1,384.0	857.9	526.1	62.0	1,245.6	526.2	719.4	42.2
Тээврийн хэрэгслийн татвар	3,070.0	682.3	2,387.7	22.2	2,745.0	318.2	2,426.8	11.6
Тээврийн хэрэгслийн оношлогоо	544.0	198.0	346.0	36.4	354.6	121.0	233.6	34.1
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,375.0	7,338.6	36.4	99.5	7,361.3	2,057.0	5,304.3	27.9
Газрын төлбөр	4,500.0	4,409.7	90.3	98.0	2,450.0	0.0	2,450.0	0.0
Бараа үйлчилгээний бусад зардал	1,379,632.3	1,248,848.8	130,783.5	90.5	825,250.0	533,755.7	291,494.3	64.7
Бараа үйлчилгээний бусад зардал	1,337,132.3	1,211,208.9	125,923.4	90.6	800,000.0	521,112.4	278,887.6	65.1
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	42,500.0	37,639.9	4,860.1	88.6	25,250.0	12,643.3	12,606.7	50.1
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	464,061.3	378,727.5	85,333.8	81.6	124,978.5	86,011.0	38,967.5	68.8
Бусад урсгал шилжүүлэг	464,061.3	378,727.5	85,333.8	81.6	124,978.5	86,011.0	38,967.5	68.8
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	93,063.3	14,414.9	78,648.4	15.5	81,228.5	50,307.7	30,920.8	61.9
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	195,198.0	195,102.8	95.2	100.0	0.0	0.0	0.0	
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	175,800.0	169,209.8	6,590.2	96.3	43,750.0	35,703.3	8,046.7	81.6
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,601,806.8	6,372,594.5	1,229,212.3	83.8	3,865,556.6	3,528,608.3	336,948.3	91.3

ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	7,556,806.8	6,317,319.3	1,239,487.5	83.6	3,843,056.6	3,499,250.9	343,805.7	91.1
Орон нутгийн төсвөөс	7,556,806.8	6,317,319.3	1,239,487.5	83.6	3,843,056.6	3,499,250.9	343,805.7	91.1
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.0	0.0	0.0		0.0	676.7	-676.7	
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	0.0	0.0	0.0		0.0	676.7	-676.7	
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	45,000.0	55,275.2	-10,275.2	122.8	22,500.0	28,680.7	-6,180.7	127.5
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	45,000.0	55,275.2	-10,275.2	122.8	22,500.0	28,680.7	-6,180.7	127.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0	0.0		0.0	243,416.2		
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	211	181	30.00	85.8	198	191	7.00	96.5
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.0	1	1	0.00	100.0
Төсвийн байгууллага	1	1	0.00	100.0	1	1	0.00	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	105	90	15.00	85.7	102	95	7.00	93.1
Удирдах ажилтан	12	10	2.00	83.3	10	9	1.00	90.0
Гүйцэтгэх ажилтан	44	38	6.00	86.4	47	46	1.00	97.9
Үйлчлэх ажилтан	49	42	7.00	85.7	45	40	5.00	88.88

2024 онд төсвийн нийт зардлын гүйцэтгэл 6,372,594.5 мянган төгрөг буюу 83.8 хувьтай байгаа нь Орон нутгийн төсвөөс санхүүжих санхүүжилтийг 1,239,487.5 мянган төгрөгөөр дутуу, урсгал зардал 1,229,212.3 мянган төгрөгийн гүйцэтгэл дутуу болон өөрийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл 10,275.2 мянган төгрөгөөр давсантай холбоотой байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг ангиллаар нь харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 784,697.1 мянган төгрөгөөр, ажил олгогчийн НДШ-ийн зардлыг 128,160.7 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 60,045.1 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 12,273.5 мянган төгрөгөөр, Нормативт зардлыг 0.4 мянган төгрөгөөр, эд хогшил урсгал засварын зардлыг 1,571.8 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 20,856.3 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 5,490.1 мянган төгрөгөөр, Бараа үйлчилгээний бусад зардлыг 130,783.5 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийг 85,333.8 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан нь байгууллагын үйл ажиллагааны орлогыг 45,000.0 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 55,275.2 мянган төгрөгөөр орлогыг төвлөрүүлж 10,275.2 мянган төгрөгөөр орлого давж, орон нутгийн төсвийн санхүүжилт 7,556,806.8 төгрөгөөр батлагдсанаас 6,317,319.3 мянган төгрөгийн санхүүжилт авч 1,239,487.5 мянган төгрөгийн санхүүжилт дутуу авснаас гүйцэтгэлээр зардал гаргах боломжгүй болсон байна.

Төсвийн гүйцэтгэлийг зардлын эдийн засгийн ангиллаар дүн шинжилгээ хийхэд төсвийн төлөвлөгөөг бодит тооцоо судалгаанд үндэслэн, эдийн засгийн ангиллаар үнэн зөв төлөвлөж байх шаардлагатай байна.

2025 оны хагас жилийн төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,292,005.1 мянган төгрөг буюу 85.2 хувьтай байгаа нь Орон нутгийн төсвөөс санхүүжих санхүүжилтийг 343,805.7 мянган төгрөгөөр дутуу, урсгал зардал 573,551.5 мянган

төгрөгийн гүйцэтгэл дутуу болон өөрийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл 127.5 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг ангиллаар нь харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 91,422.9 мянган төгрөгөөр, ажил олгогчийн НДШ-ийн зардлыг 35,971.8 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 67,300.8 мянган төгрөгөөр, Хангамж, бараа материалын зардал 6,920.4 мянган төгрөгөөр, Нормативт зардлыг 3,290.0 мянган төгрөгөөр, Эд хогшил урсгал засварын зардлыг 19,306.6 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 5,712.5 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 13,164.6 мянган төгрөгөөр, Бараа үйлчилгээний бусад зардлыг 291,494.3 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийг 38,967.5 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан нь байгууллагын үйл ажиллагааны орлогыг 22,500.0 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 28,680.7 мянган төгрөгөөр орлогыг төвлөрүүлж 6,180.7 мянган төгрөгөөр орлого давуулан биелүүлсэн мөн орон нутгийн төсвийн санхүүжилт 3,843,056.6 мянган төгрөгөөр батлагдсанаас 3,499,250.9 мянган төгрөгийн санхүүжилт авч 343,805.7 мянган төгрөгийн санхүүжилт дутуу авснаас үүдэж батлагдсан зардлын гүйцэтгэлийг гараагүй байна.

2.2.3 Нэмэлт санхүүжилтийн дансанд: Аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн 100130051415 тоот дансанд 2024 онд нийт 1,981,256.8 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, 1,816,733.9 мянган төгрөгийг 2 хөтөлбөр 7 арга хэмжээнд зориулалтын дагуу зарцуулж, 164,522.8 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас 764,222.6 мянган төгрөгийн санхүүжилт авч бараа ажил үйлчилгээний зардлаас 726,165.8 мянган төгрөгний гүйцэтгэл гаргаж, сургалтын хэвийн үйл ажиллагааны хөтөлбөрт 17,925.7 мянган төгрөгний санхүүжилт авч, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлаас гүйцэтгэл гаргаж, улсын баяр наадамд 90,000.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, бараа үйлчилгээний бусад зардлаас гүйцэтгэл гаргаж зориулалтын дагуу зарцуулжээ.

Санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар хууль тогтоомжийн хэрэгжилт, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийг тулган шалгахад дараах алдаа, зөрчлүүд байна. Үүнд:

1. Төрийн сангийн гүйлгээг цахим хэлбэрт шилжүүлсэнтэй холбогдуулан баталгаажсан цалин олгох хүснэгт, ажилтнуудын цагийн бүртгэл, холбогдох тушаал, шийдвэр зэрэг цалин олголтыг үндэслэх анхан шатны баримтын бүрдэл дутуу байхад ажил гүйлгээг гүйцэтгэж, уг төлбөрийг санхүүгийн бүртгэл, тайланд тусгасан.

2. Нягтлан бодогч нь албан ёсоор томилогдсон боловч хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг хийх үүргээ биелүүлээгүй.

3. 2025 оны хагас жилээр мөнгөн гүйлгээний тайланд цалин хөлс болон нэмэгдэл урамшлыг илүү тайлагнасан

4. 2025 оны дансны зарлагын хуулгаар 110,483 төгрөг гараагүй байхад Мөнгөн гүйлгээний тайланд зарлагын бичилт бүртгэсэн

5. Сэ.ХХОАТ-ын буцаан олголт данс руу 2025.06.19-д 1,669,500 төгрөгийн 2024 оны актын төлбөрийг гэрээт ажлын хөлс зардлаас төлж, цалингийн өглөг дансанд бүртгэсэн.

6. 2025 оны хагас жилийн санхүүгийн тайланд НДШ-ийн өглөг 23,015,175 төгрөг, ХХОАТ-ын өглөг 35,388,825 төгрөг, нийт 58,404,000 төгрөгийн өглөг тайлагнаагүй

7. Урьдчилж олгосон ээлжийн амралтын цалин 2025 оны хагас жилээр авлагаар тайлагнаагүй

8. Төсвийн гүйцэтгэлийн тайланд цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг дутуу тайлагнасан

2.3. Ажилтан албан хаагчдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдал

2024, 2025 онд аймгийн ЗДТГ-ын ажилтан албан хаагчдын цалинг тамгын газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дугаар тушаалаар, 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дугаар тушаалаар, 2025 оны 05 сарын 01-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар тушаалуудаар бүтэц, орон тоог батласан байна.

Хүснэгт №02-ээр харуулбал:

№	Албан тушаалын нэр	Орон тоо		
		2024.01	2025.01	2025.05
АЙМГИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН БҮТЭЦ				
1	Аймгийн захиргааны удирдлага	-	-	3
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НЭГЖҮҮДИЙН БҮТЭЦ, ОРОН ТОО				
2	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга	1	1	-
3	Төрийн захиргааны удирдлын хэлтэс	7	7	8
4	Хууль, эрх зүйн хэлтэс	4	4	5
5	Архивын тасаг	3	3	-
6	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс	16	15	-
7	Бус орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс	-	-	10
8	Салбарын хяналт зохицуулалтын хэлтэс	-	-	8
9	Санхүү, төрийн сангийн хэлтэс	8	8	8
10	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс	5	5	5
11	Нийгмийн бодлогын хэлтэс	5	5	6
12	Залуучууд хөгжлийн төв	3	2	-
13	Цэргийн штаб	4	4	4
14	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга	1	1	1
15	Нягтлан бодогч	1	1	1
БАЙГУУЛЛАГЫН ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХАД ТУСЛАХ АЛБАН ХААГЧДЫН БҮТЭЦ				
16	Нийтлэг үйлчилгээний алба	34	35	-
17	Архив, бичиг хэрэг	3	3	-
18	Хэвлэл, мэдээлэл	3	4	-

19	Төрийн архивын тасаг	5	5	-
20	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	-	-	3
21	Санхүү төрийн сангийн хэлтэс	-	-	1
22	Хэвлэл мэдээллийн алба	-	-	5
23	Нийтлэг үйлчилгээний алба	-	-	34
Бүгд		103	103	102

Цалингийн сан гүйцэтгэлийн талаар;

2024 онд онд аймгийн Засаг даргын тамгын газар 58 орон тоо, төрийн үйлчилгээний албан хаагч 45 орон тоо, 2025 он шинэчлэгдсэн бүтэц, орон тоогоор ажиллахаар батлагдсан. 2024 онд 90 албан хаагч, 2025 онд 95 албан хаагчдад цалинг Засгийн газрын 2018 оны 382, 2021 оны 377, 2022 оны 487, 2023 оны 312, 6, 378, 240 дугаар тогтоолууд, аймгийн Засаг даргын 2016.09.30-ны өдрийн А/262 дугаар захирамж, байгууллагын даргын 2024.01.02-ны өдрийн А/01 дугаар тушаал, 2025.01.02-ны өдрийн А/24 дүгээр тушаал, шийдвэрүүдийг үндэслэж олгожээ.

Хүснэгт 03 /төгрөгөөр/

№	зүйл заалт	2024 он	2025 оны хагас жил
1	Бодогдсон цалин	1,252,963,489	733,453,766
2	Илүү цаг нэмэгдэл хөлс	58,831,298	10,596,009
3	Хавсран, хослон, түр орлон гүйцэтгэсний нэмэгдэл хөлс	63,152,408	32,981,929
4	Ур чадварын нэмэгдэл	121,263,957	67,008,578
5	Алба хаасан хугацааны нэмэгдэл	143,325,905	91,756,219
6	Мэргэшлийн зэргийн нэмэгдэл	25,739,362	15,795,850
7	Зэргийн нэмэгдэл	95,775,604	63,263,906
8	Онцгой нөхцөлийн нэмэгдэл	24,824,399	22,649,919
9	Орон нутагт ажилласны нэмэгдэл дүн (ОН-аас нэмэгдүүлэн олгох)	391,620,248	314,266,111
10	Төрийн болон албаны нууц хамгаалах ажилтны нэмэгдэл	6,482,414	3,580,309
11	Цолны цалин	24,909,644	15,304,698
12	Хариуцлагын нэмэгдэл	1,020,969	
13	Цалингийн зөрүү	91,523,636	521,632
14	Орон нутагт ажилласны нэмэгдэл дүн (ОН-аас нэмэгдүүлэн олгох 80 хувь хүртэл)	44,542,500	138,639,413
15	Орон нутагт ажилласны нэмэгдэл дүн /Улсын төсвөөс нэмэгдүүлэн олгох/	168,129,566	
16	Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал (дүнгээр)	2,870,000	106,437,330
17	Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал (хувиар)	203,396,125	
18	Ээлжийн амралтын олговор	235,828,589	38,718,057
19	Хоолны хөнгөлөлтийн дүн	183,810,000	246,384,000
20	Нийтийн тээврийн унааны хөнгөлөлтийн дүн	860,000	427,000
21	ХЧТАТ (НДС)	489,358	1,749,417
22	ХЧТАТ (АО)	676,801	3,497,982
23	Нийт нэмэгдэл цалин хөлс /2...+22/	1,889,072,784	1,173,578,359
	Олговол зохих цалин /1+22/	3,142,036,273	1,907,032,125

ЗДТГ-ын Ажилтан албан хаагчдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдлын тушаал шийдвэр, цагийн тооцоо, цалингийн нэгдсэн систем, холбогдох бусад баримт материалтай тулган шалгахад дараах алдаа, зөрчлүүд байна. Үүнд:

1. Ажилчдад олгосон цалингийн нэмэгдлийн тооцооллыг тулган шалгахад 2024 онд 121,263.9 мянган төгрөг, 2025 оны хагас жилээр 67,008.5 мянган төгрөг нийт 188,272.5 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг зохих журмын дагуу үнэлж олгоогүй байгаа нь нэн даруй залруулаагүй нөхцөлд ноцтой үр дагаварт хүргэж болзошгүй байна.

2.4. Шилэн дансны цахим системийн хуулийн хэрэгжилт

Шилэн дансны цахим системд хяналтыг хийж хүргүүлсэн бөгөөд дахин хяналтыг 2025 оны 2025.23.14-ний өдрийн байдлаар Нийт 183 удаа мэдээлэл оруулахаас 23 хувь буюу 42 удаа мэдээлэл хугацаандаа оруулсан, 11 хувь буюу 20 удаа мэдээлэл хугацаа хоцорч мэдээлсэн. 10 хувь буюу 18 удаагийн мэдээлэл оруулах хугацаа болсон. 5 хувь буюу 10 удаагийн мэдээлэл оруулах хугацаа болоогүй, 42 хувь буюу 77 удаагийн мэдээлэл хугацаандаа оруулсан/оруюлах мэдээлэл байхгүй/, 7 хувь буюу 13 удаагийн мэдээллийг үнэн зөв мэдээлээгүй, 2 хувь буюу 3 удаагийн мэдээлэл оруулаагүй. "Байгууллагын батлагдсан төсөв"-ийн мөнгөн дүнг төгрөгөөр мэдээлэх байтал мянгачилж мэдээлсэн, , хөрөнгө мөнгө зарцуулсан шийдвэрийг мэдээлээгүй, хуулийн хэрэгжилт 62 хувьтай зэрэг зөрчилтэй байна

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1./Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ./ гэж заасныг зөрчжээ.

2.5. Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт

Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын хэрэгжилтийг хянаж үзэхэд Засаг даргын нөөц хөрөнгийг 2024 онд 1,256.6 сая төгрөгөөр батлуулж, нийт санхүүжилтийн 90 хувь буюу 1,131.2 сая төгрөгийг зарцуулсан байгаа нь тус журмын 21.1, 2.1.2-т заасан хохирлыг эхний ээлжид санхүүжүүлэхэд нийт батлагдсан хөрөнгийн 30 хувиас доошгүйг зарцуулах ба хохиролд зарцуулагдаагүй үлдэгдлийг сарын хуваариас тооцож нөөцөд бэлэн байршуулсан байх заалтыг зөрчиж 251.6 сая төгрөгөөр нөөц хөрөнгийн үлдэгдлийг хэтрүүлэн нөөц хөрөнгийн зориулалтын дагуу үр ашигтай зарцуулаагүй байна.

2.7 Орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт

Үндсэн хөрөнгийн данс бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийг хөтлөх заавар аргачлал, бодлогын баримт бичигт тусгасан арга зүйгээр үндсэн хөрөнгийн ангилал, анхны өртөг, тоо хэмжээг үнэн зөв хөтлөөгүй, орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хангалтгүй байна.

2.7.1 Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн талаар:

Хүснэгт 04 /мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2024 он				2025 он			
		2024.01.01	2024.12.31	Өөрчлөлт		2025.01.01	2025.06.30	Өөрчлөлт	
				Нэмэгдсэн	Хасагдсан			Нэмэгдсэн	Хасагдсан
1	Барилга байгууламж, орон сууц	1405998.7	1405998.7	0.0	0.0	1405998.7	1405998.7	0.0	0.0
2	Тээврийн хэсэгсэл	537700.0	880221.7	362521.7	20000.0	880221.7	880221.7	0.0	0.0
3	Машин тоног төхөөрөмж	721949.9	810403.3	128610.8	40157.4	810403.3	819581.9	9178.6	0.0
4	Тавилга эд хогшил	392127.5	519304.1	140574.9	13398.3	519304.1	519304.1	0.0	0.0
5	Бусад үндсэн хөрөнгө	70294.1	78940.1	8646.0	0.0	78940.1	78940.1	0.0	0.0
6	Програм хангамж	10593.0	10593.0	0.0	0.0	10593.0	10593.0	0.0	0.0
7	Бусад биет бус хөрөнгө	603734.0	2825366.0	2221632.0	0.0	2825366.0	2825366.0	0.0	0.0
8	Бусад хөрөнгө	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
	ДҮН	3742397.2	6530826.9	2861985.3	73555.7	6530826.9	6540005.5	9178.6	0.0

2024 оны эхэнд 3,742,397.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байсан ба тайлант онд 2,861,985.3 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, бүртгэлээс 73,555.7 мянган төгрөгийн хөрөнгө хасагдаж, оны эцэст 6,530,826.9 мянган төгрөгийн хөрөнгөтэйгээр тайлагнажээ. 2025 оны эхний хагас жилд 9,178.6 мянган төгрөгөөр хөрөнгийг нэмэгдүүлэн, хасагдсан хөрөнгө бүртгэгдээгүй тайлагнажээ.

2.7.2 Үндсэн хөрөнгийн элэгдлийн талаар:

Хүснэгт 05 /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2024 он				2025 оны эхний хагас жилээр			
	2024.01.01	2024.12.31	Өөрчлөлт		2025.01.01	2025.06.30	Өөрчлөлт	
			Нэмэгдсэн	Хасагдсан			Нэмэгдсэн	Хасагдсан
Барилга байгууламж, орон сууц	594271.0	673218.6	78947.6	0.0	673218.6	712673.8	39455.2	0.0
Тээврийн хэсэгсэл	337150.0	386394.2	69244.2	20000.0	386394.2	451354.0	64959.8	0.0
Машин тоног төхөөрөмж	456627.4	507913.2	91443.2	40157.4	507913.2	558347.8	50434.6	0.0
Тавилга эд хогшил	280614.8	294711.2	27467.8	13371.4	294711.2	321756.7	27045.5	0.0
Бусад үндсэн хөрөнгө	62513.7	65545.5	3031.9	0.0	65545.5	66676.2	1130.7	0.0
Програм хангамж	9493.0	10093.0	600.0	0.0	10093.0	10393.0	300.0	0.0
Бусад биет бус хөрөнгө	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бусад хөрөнгө	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
ДҮН	1740669.8	1937875.7	270734.7	73528.8	1937875.7	2121201.6	183325.9	0.0

Тус байгууллага нь 2024 оны эхэнд 1740669.8 мянган төгрөгийн хуримлагдсан элэгдэлтэй байсан бол тайлант онд 270734.7 мянган төгрөгийн элэгдэл байгуулж,

73528.8 мянган төгрөгийн акталсан хөрөнгийн хуримтлагдсан элдэгдэл бүртгэлээс хасч, 2024 оны эцэст 1937875.7 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэйгээр тайлагнасан бол 2025 оны эхэнд 1937875.7 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй байсан бол тайлант онд 183325.9 мянган элэгдэл байгуулж, 2025 оны эхний хагас жилийн эцэст 2121201.6 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэйгээр тайлагнажээ.

2.7.3 Бараа материалын тайлангийн өөрчлөлтийн талаар:

Хүснэгт 06. /мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2024 он				2025 оны эхний хагас жилээр			
		2024.01.01	2024.12.31	Өөрчлөлт		2025.01.01	2025.06.30	Өөрчлөлт	
				Нэмэгдсэн	Хасагдсан			Нэмэгдсэн	Хасагдсан
1	Эм боох материал	2,801.0	2,725.0	0.0	76.0	2,725.0	2,725.0	0.0	0.0
2	Бичиг хэргийн материал	24,895.3	14,950.5	43,480.9	53,425.6	14,950.5	16,027.6	14,287.0	13,209.9
3	Аж ахуйн материал	65,124.9	76,428.4	72,904.4	61,600.9	76,428.4	85,513.2	30,944.4	21,859.6
4	Сэлбэг хэрэгсэл	0.0	0.0	23,144.4	23,144.4	0.0	0.0	13,316.7	13,316.7
5	Түлш, шатах тослох материал	9,863.0	10,523.0	121,752.5	121,092.5	10,523.0	9,413.0	56,760.0	57,870.0
6	Барилгын засварын материал	475.0	776.0	32,073.3	31,772.3	776.0	748.0	8,589.1	8,617.1
7	Хүнсний материал	2,880.0	57.4	13,967.3	16,789.9	57.4	342.1	7,752.8	7,468.1
8	Бусад хангамжийн материал	50,134.0	51,754.0	1,620.0	0.0	51,754.0	51,821.0	67.0	0.0
	ДҮН	156,173.1	157,214.2	308,942.6	307,901.5	157,214.2	166,589.9	131,717.0	122,341.3

Тус байгууллага нь 2024 оны эхэнд 156173.1 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 308942.6 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж, 307901.5 мянган төгрөгийн материалыг зарцуулж, оны эцэст 157214.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэйгээр тайлагнасан бол

2025 оны эхэнд 157214.2 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 166589.9 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж, 131717.0 мянган төгрөгийн материалыг зарцуулж, оны эхний хагас жилийн эцэст 122341.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнажээ.

ЗДТГ-ын Орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтыг санхүүгийн программ, анхан шатны баримт, холбогдох бусад баримт материалтай тулган шалгахад дараах алдаа, зөрчлүүд байна. Үүнд:

Үндсэн хөрөнгө:

1. Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийн судалгаа, тооцоог гарган өмч хамгааллын байнгын зөвлөл болон ОНӨГ-ын шийдвэрээр

дахин үнэлэх буюу бүртгэлээс хасах зэрэг арга хэмжээ аваагүй 840,070,4 мянган төгрөгийн үнэтэй 376 нэр төрлийн 1880 ширхэг хөрөнгө байна.

2. Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 80,991.6 мянган төгрөгийн 2 нэр төрлийн хөрөнгийн тоо хэмжээ, анхны өртөг сольж орлогод бүртгэсэн байгаа нь өмч хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сулруулж, санхүүгийн тайлан мэдээлэл үнэн зөв илэрхийлэгдээгүй байна.

3. Үндсэн хөрөнгийн дансанд 2024 оны 07 сарын 01-д ашиглалтад орсон огноотой, 79,741,650 төгрөгийн үнэ бүхий суудлын авто машины ашиглах жилийг 1 жилээр бүртгэж, хуримтлагдсан элэгдлийг 39,870,825 төгрөгөөр байгуулж тайлагнасан

Бараа материал:

Тухайн байгууллага нь нэг жилээс дээш хугацаанд ашиглагдах, үндсэн үйл ажиллагаанд байнга ашиглах, элэгдэл тооцох шаардлагатай үндсэн хөрөнгийн шинжтэй эд хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэн тайлагнасан. Энэ нь хөрөнгийг зориулалт, эдийн засгийн агуулгаар нь зөв ангилан бүртгэх зарчим алдагдсан, санхүүгийн тайлангийн үнэн зөв, бодит байдлыг хангаагүй, хөрөнгийн тооллого, дотоод хяналт хангагдаагүй зөрчилтэй байна.

1. Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй 2 нэр төрлийн 8,266,5 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг бүртгэсэн. УСННБОУС17-Үндсэн хөрөнгө, нэгээс дээш тайлант хугацаанд ашиглагдах хөрөнгийг үндсэн хөрөнгө гэж ангилан бүртгэх, элэгдэл тооцох шаардлагыг хангаагүй.

2. Бараа материалын дансанд шохойтой цаас-1ш, баримтын утас-2ш, бор наалт-6ш, С5 дугтуй-50ш, дэвтэр бал-44ш, дэвтэр 7ш, бал-100ш, хоёр талдаа наалт-4ш, цэвэр ус-16, ус эко-25, нийт 10 нэр төрлийн 3,146,900 төгрөгийн эд хөрөнгө 2024 оны жилийн эцсийн тайланд үлдэгдлээр тайлагнасан бөгөөд 2025 оны хагас жилийн тайланд хөрөнгийн хөдөлгөөн хийгээгүй нөхцөл байдал нь бараа материалыг бодитоор ашигласан эсэх нь тодорхойгүй, эд хөрөнгийн тооллого бодитой хийгдээгүй, мөн данс бүртгэлийн тооцоо нийлсэн акт үйлдээгүй зөрчилтэй байна

Гурав. Шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, илэрсэн зөрчил дутагдал

Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын 2024 он, 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар хууль тогтоомжийн хэрэгжилт, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, цалин хөлсний тооцоолол, бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэл хөтлөлт, засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт, анхан шатны баримтын бүрдүүлэлт хангаагүй зэрэг дараах зөрчил, дутагдал илэрлээ. Үүнд:

Илрүүлэлт 1. Төрийн сангийн гүйлгээг цахим хэлбэрт шилжүүлсэнтэй холбогдуулан баталгаажсан цалин олгох хүснэгт, ажилтнуудын цагийн бүртгэл,

холбогдох тушаал, шийдвэр зэрэг цалин олголтыг үндэслэх анхан шатны баримтын бүрдэл дутуу байхад ажил гүйлгээг гүйцэтгэж, уг төлбөрийг санхүүгийн бүртгэл, тайланд тусгасан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтад "хариуцлагатай байх", 24.4.Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно., Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, 13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно., 20 дугаар зүйлийн 20.1.4-д "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтыг тус тус зөрчсөн

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг бүрдлийг хянан, хүчин төгөлдөр анхан шатны баримтаар гүйлгээ хийж хэвших

Илрүүлэлт 2. Нягтлан бодогч нь албан ёсоор томилогдсон боловч хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг хийх үүргээ биелүүлээгүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2.Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ:,12.2.2.эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед; заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тооллогыг зөвхөн нягтлан бодогч хариуцах бус, байгууллагын дотоод хяналтын баг хамтарч хийх, баримт бичгийг цахимжуулж, бүртгэлийг ил тод, хянагдахуйц байдлаар хадгалах

Илрүүлэлт 3. 2025 оны хагас жилээр мөнгөн гүйлгээний тайланд цалин хөлс болон нэмэгдэл урамшлыг 9,361,306.1 төгрөгөөр илүү тайлагнасан

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4.үнэн зөв байх; заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Мөнгөн гүйлгээний тайланг дансны хуулгатай тулгалт хийж өөрчлөлтийг үнэн зөв бүртгэж, тайлан гаргах

Илрүүлэлт 4. 2025 оны хагас жилийн мөнгөн гүйлгээний тайланд дансны зарлагын хуулгаар 110,483 төгрөгний гүйлгээ гараагүй байхад зарлагын бичилт бүртгэсэн

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4.үнэн зөв байх; заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Мөнгөн гүйлгээний тайланг дансны хуулгатай тулгалт хийж өөрчлөлтийг үнэн зөв бүртгэж, тайлан гаргах

Илрүүлэлт 5. Сэ.ХХОАТ-ын буцаан олголт данс руу 2025.06.19-д 1,669,500 төгрөгийн 2024 оны актын төлбөрийг гэрээт ажлын хөлс зардлаас төлж, цалингийн өглөг дансанд бүртгэсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4.үнэн зөв байх; заалт зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дансны бүртгэлийг үнэн зөв бүртгэх

Илрүүлэлт 6. 2025 оны хагас жилийн санхүүгийн тайланд НДШ-ийн өглөг 23,015,175 төгрөг, ХХОАТ-ын өглөг 35,388,825 төгрөг, нийт 58,404,000 төгрөгийн өглөг тайлагнаагүй

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4.үнэн зөв байх; Төсвийн тухай хуулийн 8.8.1.төсвийн шууд захирагч төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 02-ны дотор харьяалагдах төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэх; заалт зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өглөг, авлагын тайланд хуулийн хугацаанд үнэн зөв бүртгэж, хүргэх

Илрүүлэлт 7. Төсвийн гүйцэтгэлийн тайланд цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 49,494,735.59 төгрөгөөр дутуу тайлагнасан

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4.үнэн зөв байх; заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дансны бүртгэлийг үнэн зөв бүртгэх зөвлөмж өгөв

Илрүүлэлт 8. Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийн судалгаа, тооцоог гарган өмч хамгааллын байнгын зөвлөл болон ОНӨГ-ын шийдвэрээр дахин үнэлэх буюу бүртгэлээс хасах зэрэг арга хэмжээ аваагүй 840,070,4 мянган төгрөгийн үнэтэй 376 нэр төрлийн 1880 ширхэг хөрөнгө байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх "үнэн зөв байх", 5.1.5 дах "хэмжигдэхүйц байх", 20.2.4, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан журмын 7.1 дэх "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийн судалгаа, тооцоог гарган өмч хамгааллын байнгын зөвлөл болон Орон нутгийн өмчийн газрын шийдвэрийг үндэслэн шийдвэрлэх зөвлөмж хүргүүлэв.

Илрүүлэлт 9. Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 80,991.6 мянган төгрөгийн 2 нэр төрлийн хөрөнгийн тоо хэмжээ, анхны өртөг сольж орлогод бүртгэсэн байгаа нь өмч хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сулруулж, санхүүгийн тайлан мэдээлэл үнэн зөв илэрхийлэгдээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 үнэн зөв байх; 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно., 13.6.Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан

хариуцна.,ТӨЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах шилжүүлэх журам"-ын 2.3.6 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Тооллогыг үр дүнтэй зохион байгуулах, санхүүгийн тоо хэмжээ, анхны өртөгийг үнэн зөв бүртгэх

Илрүүлэлт 10. Үндсэн хөрөнгийн дансанд 2024 оны 07 сарын 01-д ашиглалтад орсон огноотой, 79,741,650 төгрөгийн үнэ бүхий суудлын авто машины ашиглах жилийг 1 жилээр бүртгэж, хуримтлагдсан элэгдлийг 39,870,825 төгрөгөөр байгуулж тайлагнасан

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 үнэн зөв байх; 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно., 13.6.Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.,ТӨЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах шилжүүлэх журам"-ын 2.3.6 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Үндсэн хөрөнгийн элэгдлийн зарлыг үнэн зөв тооцоолон өмнөх үеийн үр дүнд залруулга хийх, санхүүгийн тайланд тоон мэдээллийг зөв илэрхийлэх

Илрүүлэлт 11. Ажилчдад олгосон цалингийн нэмэгдлийн тооцооллыг тулган шалгахад 2024 онд 121,263.9 мянган төгрөг, 2025 оны хагас жилээр 67,008.5 мянган төгрөг нийт 188,272.5 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг зохих журмын дагуу үнэлж олгоогүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5."батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," Хүн амын бодлого хөдөлмөрийн сайд сангийн сайдын 196 оны 63/104 дүгээр тушаалын хавсралтын 5-д "Ажилтанд олгож байгаа ур чадварын нэмэгдлийг заасан хязгаарт багтаан нэмэгдүүлэх бууруулах, асуудлыг улирал бүр хэлэлцэн шийдвэрлэж байна", 6-д. "Энэхүү нийтлэг журмыг үндэслэн байгууллагын захиргаа нь тухайн албан хаагчид эрхэлж буй ажлын үр дүнгээр ур чадварын нэмэгдэл олгох бусад шалгуур үзүүлэлт, нэмэгдлийн хэмжээг тусгасан журмыг боловсруулан баталж, мөрдүүлнэ" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн

Шийдвэрлэсэн нь: Ур чадварын нэмэгдлийг заасан хязгаарт багтаан нэмэгдүүлэх, бууруулах асуудлыг улирал бүр хэлэлцэн шийдвэр гаргаж, ур чадварын нэмэгдэл олгох бусад шалгуур үзүүлэлт, нэмэгдлийн хэмжээг тусгасан журам боловсруулан баталж мөрдүүлж байх албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 12. Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын хэрэгжилтийг хянаж үзэхэд Засаг даргын нөөц хөрөнгийг 2024 онд 1,256.6 сая төгрөгөөр батлуулж, нийт санхүүжилтийн 90 хувь буюу 1,131.2 сая төгрөгийг зарцуулсан байгаа нь тус журмын 21.1, 2.1.2-т заасан хохирлыг эхний ээлжид санхүүжүүлэхэд нийт батлагдсан хөрөнгийн 30 хувиас доошгүйг зарцуулах

ба хохиролд зарцуулагдаагүй үлдэгдлийг сарын хуваариас тооцож нөөцөд бэлэн байршуулсан байх заалтыг зөрчиж 251.6 сая төгрөгөөр нөөц хөрөнгийн үлдэгдлийг хэтрүүлэн нөөц хөрөнгийн зориулалтын дагуу үр ашигтай зарцуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журам"-ын 3.4, 3.5, 4.3 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, нөөц хөрөнгийн үлдэгдлийг 30 хувиас доошгүй хувийг бэлэн байршуулж байх зөвлөмж хүргүүлэв

Илрүүлэлт 13. Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй 2 нэр төрлийн 8,266,5 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг бүртгэсэн. УСННБОУС17-Үндсэн хөрөнгө, нэгээс дээш тайлант хугацаанд ашиглагдах хөрөнгийг үндсэн хөрөнгө гэж ангилан бүртгэх, элэгдэл тооцох шаардлагыг хангаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтад "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" заалт зөрчсөн, богино хугацаанд зарцуулагдах хөрөнгийн ангилалд хамаарахгүй эд хөрөнгийг бараа материалд бүртгэсэн нь УСННБОУС 12-"Бараа материал"стандартын тодорхойлолттой нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь: Эд хөрөнгийг дахин ангилан, үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлж бүртгэх, ашиглалтын хугацааг тогтоож, холбогдох элэгдлийг тооцон санхүүгийн тайланд зөв тусгах, хөрөнгийн бүртгэл, ангилалд тавих дотоод хяналтыг сайжруулж зөвлөмж өгөх

Дөрөв. Дүгнэлт, шийдвэрлэлт:

4.1 Дүгнэлт:

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан удирдамжаар Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан хугацааны төсөв, санхүүгийн гүйцэтгэл, бүртгэл тайлагналт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр "Их" эрсдэлтэйд тооцож, төсвийн сахилга бат, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж дүгнэлээ.

4.2 Шийдвэрлэлт:

Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар нийт **1,291,465.2** мянган төгрөгийн 13 зөрчил илэрснээс санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн зөрчлийг таслан зогсоох 188,272.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 1,103,192.7 мянган төгрөгийн 12 зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэхээр тус тус шийдвэрлэв.

Тав. Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж:

хийсэн эрсдэлийн үнэлгээгээр "Их" эрсдэлтэйд тооцож, төсвийн сахилга бат, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж дүгнэлээ.

4.2 Шийдвэрлэлт:

Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар нийт **1,276,401.6** мянган төгрөгийн 12 зөрчил илэрснээс санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн зөрчлийг таслан зогсоох 188,272.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 1,088,129.0 мянган төгрөгийн 11 зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэхээр тус тус шийдвэрлэв.

Тав. Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж:

Шалгалтын явцад тус байгууллагын дарга, нягтлан бодогч, шалгалтаар илэрсэн зөрчилд хамаарал бүхий холбогдох албан хаагчтай уулзаж асуулга, тодруулга авч Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа явуулсан болно.

Шалгалтаар илэрсэн зөрчилт үйлдлүүд нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөл болох тул холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилт, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журамд нийцүүлэн ажиллах шаардлагатай байгааг тус аймгийн ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч, бусад холбогдох ажилтнуудад танилцуулж, зөвлөмж өгч шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг анхаарууллаа.

Санхүүгийн хяналт шалгалтын тэмдэглэлд тусгагдсан зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийн тайланг нотлох баримтын хамт 2026 оны 03 дугаар сарын 25-ны дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд албан бичгээр ирүүлэхийг тус аймгийн ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч нарт хариуцуулав.

БИЧСЭН.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД
АУДИТЫН ГАЗРЫН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ,
АХЛАХ ДОТООД АУДИТОР



Т.МӨНХЗУЛ

ТАНИЛЦСАН.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Ө.СУВДАА



НЯГТЛАН БОДОГЧ

Ц.УРАНЦЭЦЭГ